

Х.ПЭРЛЭЭ БАГШИЙН ТУХАЙ ДУРСАМЖ**Ц.ЖАМБАЛСҮРЭН**

Бид (эрдэмтэн түүхчдээс З.Лонжид, Т.Хүрэлбаатар, Ж.Болд) нар 1966-1970 онд түүхийн ангид суралцаж төгссөн, Пэрлээ багшийн жинхэнэ шавь нар нь билээ. Оюутан ахуй цагт Монголын түүхчдийн дунд нэр алдар нь мөнхөрсөн том эрдэмтдээр хичээл заалгах юмсан гэж боддог, тэр хүсэл маань ч биелсэн юм. 20-р зууны монголын түүхчдийн ноён оргилууд болсон Б.Ширэндэв, С.Пүрэвжав, Ш.Нацагдорж, Ш.Бира, Ч.Далай, Ишжамц, Гонгор, Х.Пэрлээ, Г.Сүхбаатар нарын лекцэнд сууж байснаараа бид бахархдаг билээ. Х.Пэрлээ багшийг оюутнууд хичээл заахаас нь ч өмнө сайн мэддэг, Монголын нэг номерийн археологч гэж тооцдог байлаа. 1-р курсээ төгссөн зун манай ангийхан археологийн практик хийхэд Х.Пэрлээ багш удирдсан юм. Дадлагад гарахын өмнө оюутнууд юуг анхаарах талаар нилээн дэлгэрэнгүй ярьж байхыг нь сонсоодхол явахдааав, ээж анхааруулж ярьж байгаа мэт л санагдаж байлаа. Машин дээр пүүгээ ачаагаа яаж ачихыг, суухыг хүртэл зааж, хэн нь дунд, хэн нь захад суухыг хүртэл хэлж өгч, эмэгтэй оюутнуудыг дундаа авч, ажиллаж байгаад ирсэн “доги” оюутнуудыг захад суухыг зөвлөж байлаа. Машины хөдөлгөөн дунд босож болохгүй гэдгийг ч хэлж байлаа. Том эрдэмтэн хүн гэхэдийм нарийн ширийн зүйл ярьдаг тун анхаарал халамжтай хүн байсан юм. Зам зуураа ойрхон зогсож, оюутнуудаа амрааж, байгалын сайханд сэтгэлийг нь сэргээхээ ч мартдаггүй хүн байв.

Бид Хэнтий аймгийн Дэлгэрхан сумын нутагт Аурагийн балгастархеологийн малталт хийж хэд хоносон билээ. Майхнаа хаана, яаж татах, гадуур нь борооны хамгаалалт яаж хийх, галаа хаана гаргах зэрэг бүх л асуудлыг явдал дундаа зугууханд нь өөрөө оролцон бидэнд зааж өгч байлаа. Очиж буудалласан оройгоо бид бөмбөг тоглож хөгжилтэй нь аргагүй байлаа. Нарийн төвөгтэй, чимхлүүр, бас ч гэж зуны халуунд газар ухах тун төвөгтэй ажлын урьд оюутнуудынхаа сэтгэл санааг өндөржүүлэх, газар орчинд нь дасгах багшийн арга ухаан байсан юм билээ. Тэр ч байтугай багш оюутан бидэнд тэр хавь орчны байгалын сайхныг магтаж, халуун буцалж буй рашааныг үзэх, амсахыг ч бидэнд зөвлөв. Бараг л рашаан сувилалын амралтанд ирсэн мэт л бид байцгаалаа.

Бидэнтэй цуг Зөвлөлтийн эрдэмтэн археологч Новгородова багш явсан бөгөөд хээр хөдөө явж сурсан хүн гэдэг нь бидэнд ойлгогдож байлаа. Харин Х.Пэрлээ багш нэг л завгүй маягтай майхандаа юм янзалж, бичиг цаасаа дэлгэн уншиж, бас зураг зурж, газар дээр хэмжилт хийж алхаж нилээн ажилласан юм. Оройхон тийш зан ааш улам сайхан хөгжилтэй болчихсон, оюутнуудад үлгэр хууч сонин сайхан, анекдот ярьчихсан ер нь л их сайхан болж билээ. Тэр үедээ бид

ойлгосонгүй, юу ч бодоогүй, харин хожим нь бодохноо аян замын алжаалаа тайлж их ажлын өмнө ганц хоёр хундага юм татсан юм билээ. Харин оюутнуудын хувьд архи уух гэж юм ер нь байгаагүй, толгойнд ч орж ирдэггүй, ер нь л огт танил биш зүйл байв.

Маргааш нь жинхэнэ дадлага эхлэв. Ер нь л цагаан цулгай, бүр атаршиж эдгэрсэн газрын хаана нь юуг ухах юм бол гэж л бид бодож байлаа. Пэрлээ багш газар дээр хэмжилт хийгээд дэнд энд малтах хэрэгтэй гэж зааж өглөө. Яг л тэр газар нь бид ухахад тэнд байсан эртний байшингийн багануудыг нь бид гаргаад ирж билээ. Чухам яаж багш тийнхүү нарийн зөв тодорхойлсныг одоо ч тайлбарлахад бэрх. Мэргэжлийн нарийн ухаан, археологч хүний тооцон бодох нарийн арга гэж тийм байж билээ.

Бид малталтаа цааш үргэжлүүлэв. Багш биднийг аядуузөөлөн ажиллахыг зөвлөлөө. Учир нь олдож болох түүхийн дурсгалт зүйлсийг эвдэж гэмтхээс сэргийлж буй ажээ. Эд өлгийн зүйл гарч эхэлсэн тэр үед багш биднийг бүр алгуур нарийн нягт ажиллахыг шаардаж хүрэээр биш модоор, бүр гараар зөөлөн малт гэлээ. Ийм маягаар бид анхааралтай ажилласны үр дүнд нилээн эд өлгийн зүйл олсон юм. Тэр зүйлсийг багш маш сайн цэвэрлэхийг бидэнд даалгалаа. Эцэст нь багш нар тэр зүйлсийн фото зураг авч, гар зураг зурж, хэмжилт хийж, тусгай хайрцаг сав бэлдэн боож, савлаж билээ.

Энэ бүх ажлыг хийхдээ багш тун тайван, үг дуугаа цөөрүүлж, цөөн оновчтой үгээр тайлбарлах зүйлээ хэлж байлаа. Тавь гарч байсан байх, гэвч багшийн хөдөлгөөн хөнгөн, гар нь бараг л уран сийлбэрч хүн шиг нямбай ажиллаж байсныг тод санаж байна.

Пэрлээ багш ер бусын эртэч хүн байлаа. Оюутан бид нар дуудуулж байж л босно. Гэтэл багш аль эрт босчихсон хол ойрыг ажиглан алхаж явна. Олон хоног хамт байсан гэхэд уурлаж уцаарлаж байхыг төдийгүй сандарч бухимдаж байхыг нь огт ажиглаагүй бөгөөд үнэхээрийн сайхан тайван дөлгөөн зантай хүн байсан нь оюутан бидний сэтгэлд яг л тэр чигээрээ үлджээ.

Бид 3-р ангид байхад Пэрлээ багш бидэнд “Сурвалж судлал” гэдэг нэн чухал сонин хичээл зааж байлаа. Монголын түүхийн эх сурвалж болсон олон зохиолын тухай шинэ мэдээллийг бид олж авч байлаа. Багш албаны лекц маягаар биш ер нь оюутнуудад ойрхон ойлгомжтой хэлээр үзүүлэн ярих, харилцан ярих хэлбэрээр хичээлээ явуулдаг хүн байлаа. Хэтэрхий энгийн мөртлөө оюутанд ойлгомжтой, сонирхолтой түүний лекцийг манай ангийхан тасладаггүй байсан юм.

Ялангуяа эртний улсуудын үеийн түүх бичлэг бидэнд сонин байсан бөгөөд харин хамгийн сонирхолтой нь эзэнт гүрний үеийн түүх бичлэгийн асуудал байлаа. “Монголын нууц товчооны” тухай ярихдаа багшийн нүд нь сэргэж, бид урьд нь уншсан ч гэсэн анализ дүгнэлт хийж чадаагүй тийм сонин дүгнэлтийг хэлж өгдөг байлаа. Чингэс хааны уг гарал, намтар түүхийг их л хичээнгүйгээр ярихдаа дэвтэр

ном хардаггүй, хүний нэрийг нь самбарт бичээд л цээжээр ярьдаг байлаа.

Чингэс эзний алтан ургийн түүх Гангын урсгал нэрт бичиг оршив хэмээх номыг их ач холбогдол өгч нилээн дэлгэрэнгүй ярьж, ер нь Манжийн ноёрхолын үеийн түүх бичлэгийн сор болсон бүтээл гэж үздэгээ хэлж байсан. Энэ зохиолыг нь бид олж унших гээд тэр үедээ л амжаагүй. Учир нь нийтийн хүртээл болгон хэвлээгүй байсан юм.

Пэрлээ багшийн алгуур тайвнаар ярих мөртлөө өөрийнх нь итгэл үнэмшил, үзэл бодол шингэсэн лекцүүд ямар ч л гэсэн нэг хэсэгтээ сэтгэлд хоногшдог байлаа. Багш ном, зохиол унших даалгавар өгдөг ч албадаж шахах арга огт хэрэглэдэггүй хүн байсан. Харин оюутнууд бид даалгаварыг нь яаж ийгээд л биелүүлчих юмсан гэж хичээдэг байсан юм.

Бид сургууль төгссөний дараа багштай уулзах учрах тоолонд нэрээр дуудаж, ажил амьдрал сонирхон ярьж хөөрөх дуртай хүн байлаа. Хүний нэр цээжлэхдээ сайн байсан. Олон мянган шавьтай, том эрдэмтэн, алдартай хүн гэхэд жирийн залуу багш миний нэрийг огт марталгүй дуудаж дотночлон ярьдаг, тун эгэл хүн байсныг би одоо ч дурсан санадаг.

“Их мөрөн дөлгөөн” гэж ихэс дээдсийн үг байдаг. Пэрлээ багш ийм л ухаалаг дөлгөөн хүн байсан. Эрдэм ухааны хувьд гэвэл ер нь 20-р зууны Монголын түүхчдийн хувьд Геродот л байсан гэж бодном. Тэр хүний ухааны цар, олон талын авъяас билэг, зөөлөн ухаалаг зан төрх, учиртай, нэгийг бодогдуулсан үг яриа, тайван намбалаг нүдэнд дулаахан сайхан дүр шавь бидний хувьд үлгэр дууриалал болж байдгийг би сэтгэлийн гүнээс хэлэх үүрэгтэй билээ.